

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2014 ОНД ГАДААД АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж газар нь Засгийн газрын 2013 оны 196 дүгээр тогтоолоор батласан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам” Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/153 захирамжаар батласан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын гадаад харилцааны үйл ажиллагааны журам”-ыг гадаад арга хэмжээнд мөрдөн ажиллалаа.

2014 онд дараах гадаад арга хэмжээнд оролцлоо. Үүнд:

1. БНСВУ-ын Хочимин хотод 2014.4.10-17- ны өдрүүдэд “Оёдол, нэхмэл, гутлын үйлдвэрлэлийн чиглэлээр” БНСВУ-д Хочимин хотод аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллийг туршлага судлахаар ҮХААЯамны Хөнгөн үйлдвэрлэлийн бодлого зохицуулалтын газрын орлогч дарга С.Рэгзэдмаа, Тус газрын мэргэжилтэн Н.Нарангэрэл, аж ахуйн нэгжийн төлөөлөл, НҮХААГ-ын Үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Т.Цэрэндэжид нар оролцов.

Уг томилолтоор: Монголын төлөөлөгчид Вьетнам Улсын хөнгөн үйлдвэрийн салбарын бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдтэй харилцаа холбоо тогтоож, хамтын ажиллагааг эхлүүлэх, оёдол, нэхмэл, гутлын үйлдвэрлэлийн чиглэлээр Хочимин хотын пүүс, компаниудын үйл ажиллагаа, туршлагатай танилцлаа.

Вьетнамын Нэхмэл, сүлжмэл эдлэл үйлдвэрлэгчдийн холбоо, Вьетнамын оёмол, сүлжмэл эдлэлийн үндэсний корпораци, Вьетнамын Савхин эдлэл, гутал, гар цүнх үйлдвэрлэгчдийн холбоо, дэлхийн нэртэй бренд хувцаснуудыг үйлдвэрлэдэг “Сайгон” худалдааны корпораци, “Нья Бэ” корпораци болон “Бинь Дыонг” аж үйлдвэрийн парк зэрэг үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд тус тус зочиллоо.



Монгол Улсын Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, БНСВУ-д суугаа Элчин сайдын яам, Вьетнам Улсын Үйлдвэр, худалдааны яамтай хамтран Монгол-Вьетнамын бизнес уулзалтыг Хочимин хотноо зохион байгууллаа. Уулзалтын үеэр монголын хөнгөн үйлдвэрийн салбарын төлөөлөгчид Монголын бараа, бүтээгдэхүүний дээжийг Вьетнамын бизнес эрхлэгчдэд танилцуулав.

2. БН Австри улс, Вена хотод 2014.4 .20-30 өдрүүдэд “Дотоодын хүнсний бүтээгдэхүүнээр Улаанбаатар хотыг хангах” ажлын хүрээний уулзалт албан томилолтоор Нийслэлийн Үйлдвэр, Хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэн, Нийслэлийн Үйлдвэр, Хөдөө аж ахуйн газрын Газар тариалангийн хэлтсийн дарга Ц.Төмөртулга, НЗДТГ-н Төсөл хамтын ажиллагааны хэлтсийн Австрийн төслүүд хариуцсан ажилтан Р.Эрдэнэ нар оролцов.



Уг томилолтоор: Монгол улсын нийслэл Улаанбаатар хот, Австри улсын Раумберг Гумпенштейн Хөдөө аж ахуйн боловсрол, шинжлэх ухааны төв /хамтад нь талууд гэх/- тэй хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн салбарын бүтэц, зохион байгуулалт болон Улаанбаатар хот орчимд эрчимжсэн фермийн аж ахуйг хөгжүүлэх талаар судалгаа явуулах, “Улаанбаатар хотын иргэдийн хүнсний хангамжийг сайжруулах” төслийн концепци боловсруулах талаар санал солилцон, хамтран ажиллахаар тохиролцов.

3. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод 2014.05.12-16-ны өдрүүдэд ӨМӨЗО-ны Үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаатай танилцах, хамтран ажиллах боломжийг судлах албан томилолтоор Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Т.Бат-Эрдэнэ, Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэн, ЖДҮ-ийг дэмжих төвийн дарга Б.Одгэрэл, Мэргэжлийн хяналтын газрын дарга М.Ням-Очир, Мал эмнэлгийн газрын дарга А.Нарантуяа нар оролцов.



Уг томилолтоор: Чень И-Хөх хотын дарга, Ган-бөх- Хөх хотын орлогч дарга, Фань Айжи-Хөх хотын Хөдөө аж ахуйн газрын дарга, Гө Чэнган-Хөх хотын Худалдааны газрын дарга, Ли Гүнгэ- Хөх хотын Гадаад харилцааны газрын орлогч дарга нар болон албаны бусад хүмүүстэй уулзлаа.

Нийслэлийн иргэдийн сүүний хангамжийг сайжруулах зорилгоор сүүний чиглэлийн 250 үнээний ферм байгуулах талаар хүсэлт тавьж, танилцуулга хийгдсэн. Мөн хүлэмжийн аж ахуй, мөөгний аж ахуй, мал эмнэлэг болон мэргэжлийн хяналтын чиглэлээр сургалт зохион байгуулах хүсэлт тавьсан. Хүнсний бүтээгдэхүүний болон эмийн хяналтын удирдлагуудтай уулзалт хийж, Сайхан дүүргийн хүлэмжийн аж ахуй, хүнсний ногоо, зэрэг газар тариалангийн үйл ажиллагаатай танилцав.

Хөх хотын Худалдааг дэмжих нийгэмлэгийн удирдлагуудтай уулзаж мэдээлэл солилцлоо. Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Бат-Эрдэнэ саналаа хэлж үзэсгэлэн худалдаанд оролцох хамтран зохион байгуулах, нийслэлийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах худалдааны төв бий болгох талаар хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа танилцууллаа.

ӨМӨЗО-ы Мэнцоканхан цөлжилтийн эсрэг өвс модны үржүүлэг, судалгааны төв, Хөх хотын Мэн ню сүүний үйлдвэр, Махны чиглэлийн хонины аж ахуйн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцлаа.

Нийслэлийн Засаг даргын орлогч Т.Бат-Эрдэнийн албан ёсны айлчлал үр дүнтэй болсон бөгөөд олон ажлын эхлэлийг тавьсан арга хэмжээ боллоо. Талууд дараах чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцов. Үүнд:

- Сүүний чиглэлийн 250 үнээний ферм байгуулах болон хүлэмжийн аж ахуй, мөөгний аж ахуй, мал эмнэлэг болон мэргэжлийн хяналтын чиглэлээр сургалт зохион байгуулах хүсэлтийг мэргэжлийн байгууллагуудад тавьж, ойрын хугацаанд албан ёсоор хариу өгөх,
- 2014.05.18-22 хооронд зохион байгуулагдах үндэсний үзэсгэлэн худалдаанд оролцох,
- Багшийн их сургуультай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсны дагуу үйлдвэр эрхлэгчдийг сургалтанд хамруулах зэргээр хамтарч ажиллах болсон.

4. БН Австри улс, Вена хотод 2014.06.21 -25 өдрүүд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч албан айлчлалд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Ц.Энхцэнгэл, Нийслэлийн Үйлдвэр, Хөдөө аж ахуйн газрын дарга Г.Пүрэвсүрэн, Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын дарга Ч.Мөнхзул, НЗДТ-ын Нутгийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Ү.Ганболд, НЗДТ-ын Гадаад харилцааны хэлтсийн дарга Д.Наранцэцэг, Засаг даргын ажлын албаны төсөл хариуцсан ажилтан Р.Эрдэнэ нар оролцов.

Уг айлчлалаар: Монгол улсын нийслэл Улаанбаатар хот, Австри - Монголын нийгэмлэг /хамтад нь талууд гэх/- тэй хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн салбарын бүтэц, зохион байгуулалт болон Улаанбаатарт хот орчимд эрчимжсэн фермийн аж ахуйг хөгжүүлэх талаар судалгаа явуулах, "Улаанбаатар хотын иргэдийн хүнсний хангамжийг сайжруулах" төслийн концепци боловсруулах талаар санал солилцлоо.

Мөн Нийслэлийн бэлчээрийн менежмент, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөтөлбөр боловсруулах, хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан. Уг санамж бичгийн хүрээнд "Хот орчимын бэлчээрийн менежментийг сайжруулах" хөтөлбөрийг 2015 оны төсөвт санал оруулан хэрэгжүүлэхээр болсон.

5. БНСУ-ын Даежён хотод 2014.10.27-ноос 2014.11.17 өдрүүдэд "Шинжлэх ухаан технологийн паркийн хөгжил" сургалт, семинар албан томилолтоор Нийслэлийн Үйлдвэр, Хөдөө аж ахуйн газрын Үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн Б.Ганцэцэг оролцов.



Уг томилолтоор: нийт 17 орны 23 төлөөлөгчид хамрагдсан байгаа. Нийт 11 удаагийн лекц, семинар орсон ба тухайн хичээлтэй холбогдолтой уулзалт, аялалууд зохион байгуулагдлаа.

Шинжлэх ухаан технологийн паркийн уулзалт семинараар дараах сэдэвт лекцүүд орлоо. Үүнд:

- Солонгос улсын бүсийн болон бүсийн инновацийн систем
- Солонгос улсын эдийн засгийн хөгжилд шинжлэх ухаан технологийн үүрэг роль
- Солонгос улсын Үйлдвэрлэлийн шинэ бодлого
- Технологийг эдийн засгийн эргэлтэд оруулах
- Технологийн үнэлгээний систем ба технологийн санхүүжилт
- Солонгос улсын мэдээлэл технологийн хөгжил
- Шинжлэх ухаан технологийн паркийн хөгжлийн стратеги
- Шинжлэх ухаан технологийн паркийн бизнес төлөвлөгөө
- Innopolis дэмжих программ технологи
- Солонгос улсын эдийн засгийн хөгжил, түүний үр дагавар

Энэхүү сургалтаар иновацийн онолын мэдээллийг олж авч, дээрх сэдвүүдээр Солонгос улсын туршлагаас суралцлаа, хэрхэн Шинжлэх ухаан технологийн парк хэрхэн үүсч хөгжсөн, ямар ямар бэрхшээл тулгарч, Мөн түүнийгээ туулж гарсан талаарх мэдээллийг сонслоо. Түүнчлэн Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлснээр улс орны хөгжил, эдийн засагт ямар их хувь нэмэр оруулдгийг олж мэдлээ.

6. Япон улсын Цукуба хотын Цукубагийн Их Сургууль 2014.10.13-25-ны өдрүүд “Байгаль орчны шинжлэх ухаан - Тогтвортой байгаль орчин” сэдэвт сургалт албан томилолтоор Д.Баялагцэнгэл /НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн/ Ч.Болдбаатар/БОНХГ-ын Ой, ногоон байгууламжийн хэлтсийн дарга/ К.Марат /БОНХГ-ын Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хэлтсийн дарга/ Ц.Шижир /НӨХГ-ын Газар өмчлөл, өмчийн менежментийн хэлтсийн ахлах мэргэжилтэн/ П.Эрдэнэсүрэн /НҮХААГ-ын Үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн/ Ч.Чулуунцэцэг /НҮХААГ-ын Үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн/ М.Идэрбаатар /НЕТГ-ын Хот байгуулалт, дэд бүтцийн хяналтын албаны инженер/ нар оролцов.



Уг томилолтоор:

- Япон улсын байгаль орчны бохирдлын түүх;
- Байгаль орчны микробиологи /хөрс цэвэршүүлэх биологийн болон ургамлын нөхөн сэргээлт/;
- Цаг уурын өөрчлөлт;
- Хог хаягдлын менежмент;
- Байгаль орчны удирдлага;
- Бодлого төлөвлөгчдийн байгаль орчны ёс зүй;
- Биологийн нөөцийн дахин боловсруулалт, ашиглалт;
- Байгаль орчны боловсролыг хүүхдэд олгох нь;
- Япон улсын хөрсны бохирдолтой тэмцэх эрх зүйн зохицуулалт зэрэг чиглэлээр судалж, мэргэжил дээшлүүлсэн.

Сургалтын явцад дараах байгууллагад хэрэгжиж буй төсөл, арга хэмжээтэй танилцсан.

- Нэгдсэн үндэстний байгууллагын Токио дахь салбар их сургуульд “Хотын тээврийн салбар дахь үр ашгийн үнэлгээний хэрэгсэл” танилцуулга
- Цукуба хотын захиргааны Байгаль орчны газарт “Нүүрстөрөгчийн хийг бууруулах төсөл”

Байгаль орчны судалгааны үндэсний институтэд “Агаарын чанарыг үнэлэх аргачлал” зэрэг төслүүдтэй танилцаж, туршлага судаллаа.

2014 Санхүүгийн асуудлаас шалтгаалан хийгдээгүй гадаад арга хэмжээ

7. БНХАУ-ын Вэнгжүгийн "China International Industry Exhibition 2014" үзэсгэлэнд хамтран оролцох санал болон бусад холбогдох мэдээллийг Монголын мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөл болон сав баглаа боодлын холбоо, оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо, ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, хүнсчдийн холбоодод 2014 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хүргүүлсэн. Үзэсгэлэнд нийслэлийн төлөөлөгчид болон аж ахуйн нэгж байгууллагуудыг зохион байгуулж оролцуулах тухай НЗД-ын захирамжийн төсөл, зардлын тооцоо, удирдамж, танилцуулгыг НЗДТГ-ын Гадаад харилцааны хэлтэст 2014 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 05/71 албан бичгээр хүргүүлсэн гэвч үйлдвэр, аж ахуйн нэгжүүдээс санхүүгийн байдлаас шалтгаалан тодорхой санал ирүүлээгүй тул уг ажил хийгдээгүй болно.

8. Засгийн газрын 2014 оны 5 сарын 10-ны 147 дугаар тогтоолын дагуу нийслэлийн төр захиргааны байгууллагаас оролцохгүй болсон тул АНУ-ын Чикаго

хотноо 2014 оны 09 сарын 08-аас 13-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Аж үйлдвэрийн тоног төхөөрмжийн олон улсын үзэсгэлэн”-гийн талаарх мэдээллийг албан тоотоор мэргэжлийн холбоодод хүргүүлсэн санхүүгийн байдлаас зэргээс шалтгаалан Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдээс санал ирүүлээгүй тул үзэсгэлэнд оролцоогүй болно.

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР